



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/02

Хараат

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын 6.1, 6.2 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч: Н.Батгэрэл (Засаг даргын орлогч)  
Нарийн бичгийн дарга: - Б.Цэрэнмаа (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн )  
Гишүүд: - Ч.Бямбасүрэн (ИТХ-ын нарийн бичгийн дарга)  
- Т.Өлзийбат (Мал эмнэлэгийн тасгийн дарга)  
- З.Ням (Төрийн сангийн мэргэжилтэн)  
- Б.Цэрэнмаа - (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)  
- Н.Лхагва-Учрал (Газрын даамал)  
- С.Хүрэлхуяг (Иргэний төлөөлөл)  
- Ч.Готов (Иргэний нийгмийн төлөөлөл)

2. Багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого, ард иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн хэлэлцэж, жагсаалтыг хуулийн хугацаанд боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Батгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Уг захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 11 -ний өдрийн А/06 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДОНЭСАЙХАН



4823000002